



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/851

Улаанбаатар хот

Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26 дугаар тогтоол, “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 9.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилтын хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, холбогдох нутгийн захиргааны байгууллагуудыг мэдээлэл, арга зүйгээр ханган ажиллахыг Нийслэлийн Хотын стандарт, хяналтын газар (С.Төмөрдулам)-т даалгасугай.

3.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг дүрмээр хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд хэрэгжүүлж, төлөвлөгөөний биелэлт, явц, үр дүнг 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад үүрэг болгосугай.

4.Энэ захирамжийн хэрэгжилтэд хариуцсан чиг үүргийн хүрээнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн, Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч З.Төмөртөмөө нарт даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



111020004154